



"МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО"-НЫ ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ХОЛБООНЫ БАГА ХУРЛААР УДИРДАХ ЗӨВЛӨЛ, НАРИЙН БИЧГИЙН ДАРГАА СОНГОЖ, ЦААШДЫН АЖЛАА ТӨЛӨВЛӨВ

Тойм МЭДЭЭ:

© 2019-11-25

"МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО"-НЫ ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ХОЛБООНЫ БАГА ХУРЛААР УДИРДАХ ЗӨВЛӨЛ, НАРИЙН БИЧГИЙН ДАРГАА СОНГОЖ, ЦААШДЫН АЖЛАА ТӨЛӨВЛӨВ

Цэрэг, эх оронч, үндэсний үзэл бахархлыг хөгжүүлэн, ард түмнээ соён гэгээрүүлж, Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын оюуны дархлаа, үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлэх үйлст төр, иргэний нийгмийн байгууллагууд, цэргийн үүрэгтнүүд, иргэдийг нэгтгэх зорилгоор 2019 оны 4 дүгээр сард тус тусдаа үйл ажиллагаа явуулж байсан цэргийн мэргэжлийн холбоодыг нэгтгэн "Монгол цэргийн нэгдсэн холбоо" Төрийн бус байгууллага үүсэн байгуулагдаж тэргүүнээр нь Монгол улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх сонгогдсон билээ. Улмаар өнгөрсөн 9 дүгээр сарын 06-ны өдөр "Монгол цэргийн нэгдсэн холбоо"-ны Хэнтий аймаг дахь салбар холбоог байгуулж Тэргүүнээр аймгийн Засаг дарга Н.Ганбямба сонгогдсон



Тэгвэл өнөөдөр /2019.11.15/ "Монгол цэргийн нэгдсэн холбоо"-ны дүрмийн дагуу сум бүрээс гурваас доошгүй бэлтгэл офицер, ахлагч, цэргийн үүрэгтэн төлөөлөгчдийг урьж, 80 шахам хүний бүрэлдэхүүнтэй Хэнтий аймаг дахь салбар холбооны бага хурлаа зохион байгуулсан байна. Хурлын зохион байгуулалтыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас зохион байгуулсан бөгөөд /удирдах зөвлөл, НБД сонгогдтол/ бага хурлаар салбар холбооны үйл ажиллагааг шууд удирдан зохион байгуулах Удирдах Зөвлөлийг гишүүдээрээ хэлэлцэн сонгож, нарийн бичгийн даргаа томилон, гишүүддээ дүрмээ танилцуулаа. Үүнчлэн гишүүдтэйгээ зохион байгуулалт, гишүүнчлэл, ажлын байр, төсвийн талаар санал солилцож, бага хурлаа өндөрлүүлээ.



Салбар хорооны удирдах зөвлөлийн гишүүдээр Бэлтгэл хурандаа Д.Сайнболд, Бэлтгэл хурандаа Д.Батжаргал, Бэлтгэл дэд хурандаа Д.Дангаасүрэн, Бэлтгэл дэд хурандаа Д.Ганхуяг, Бэлтгэл дэд хурандаа Ш.Ганбат, Б/Х Н.Ганпүрэв, Б/А Р.Ганхүү, Б/А Д.Борхүү, Б/А С.Наранбадрал, Б/Д Ш.Отгонжаргал, Б/Д А.Даваадорж, Б/Д М.Ган-Эрдэнэ, Б/Д Г.Болд, Б/Т Р.Бадрах, Б/Т Р.Сүхбаатар, Б/Т П.Энх-Амгалан нар 100 хувийн дэмжлэг аван сонгогдлоо. Түүний дараа удирдах зөвлөлийн гишүүд нарийн бичгийн даргаа хэлэлцэж, Цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Цэдэндамбын Батсайхан сонгогдлоо.

Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбар холбоо нь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас тэтгэвэр чөлөөнд гарсан болон одоо алба хааж байгаа бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, энхийн бүтээн байгуулалтад гавьяа байгуулсан төр, цэрэг, цагдаагийн албан хаагчид хөдөлмөр, соёл урлаг, шинжлэх ухааны зүтгэлтэн, иргэдийг алдаршуулах, түүхэн тэмдэглэлт үйл явдлуудын үеэр хүүхэд залуучуудыг соён гэгээрүүлэх зэрэг төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Нэрээ бичнэ үү

Save my name, email, and website in this browser for the next time I comment.

Сэтгэгдлээ бичнэ үү

Илгээх



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР



ХЭНТИЙ АЙМГИЙГ 2021-2025
ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН
ЧИГЛЭЛ



ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2021
ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ